

## ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨӨЛӨЛ “ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН САНАЛ СОЛИЛЦОО-2017” ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦЛОО

**Foros Semana**  
Los debates que el país necesita

**CommDev**  
Leveraging benefits to communities

**IFC** International  
Finance Corporation  
WORLD BANK GROUP

IFC INFRASTRUCTURE & NATURAL RESOURCES

**SUSTAINABILITY  
EXCHANGE**  
Taking it to the streets

✦ Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн гишүүд Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-аас жил бүр зохион байгуулдаг “Тогтвортой байдлын санал солилцоо-2017” олон улсын бага хуралд амжилттай оролцоод ирлээ. 2017 оны зургадугаар сарын 7-8-нд Колумб улсад зохион байгуулсан уг бага хуралд Гурван талт зөвлөлийг төлөөлж, Ханбогд сумын Жавхлант багийн малчин Ө.Баттогтох, тус сумын байгаль орчны улсын байцаагч Б.Алтангэрэл, “Оюу толгой” компанийн Орон нутгийн харилцаа, түншлэлийн менежер О.Цэрэннадмид нар салбар хуралдааны гол илтгэгчээр оролцож,

Эрх зүйн хяналт нийцэл зөвлөгөө омбудсмений газар (ЭЗХНЗОГ)-т гаргасан гомдлыг барагдуулах үйл явцад асуудлаа шийдэхийн тулд хэрхэн хамтарч ажилласан туршлага, тулгамдсан асуудал, бэрхшээлээсээ хуваалцав. Зөвлөлийн гишүүн, “Оюу толгой” компанийн Байгаль орчны менежер Н.Эрдэнэбаяр тус бага хуралд компанийг төлөөлж оролцсон юм.

Олон улсын энэхүү бага хурал нь зах зээлийн хөгжиж буй орнуудын дэд бүтэц, байгалийн нөөцийн салбарынханд тулгарч буй үйл ажиллагаа, байгаль орчны болон нийгмийн асуудлууд,

тэдгээрийн боломжуудын талаар хэлэлцдэг юм. Бизнес болон нийгмийн салбарынхны хооронд мэдээлэл хуваалцах, илэн далангүй яриа өрнүүлэх, санал солилцох зорилготой олон улсын энэхүү уулзалтад 300 орчим удирдах ажилтан, мэргэжилтнүүд, компаниуд, ТББ, төрийн байгууллага, олон улсын хөгжлийн агентлагуудын төлөөлөл урилгаар оролцлоо. Энэ жилийн хурлаар зах зээлийн өөрчлөлт, өвөрмөц шийдлүүд, тэдгээрийг харьцуулан жиших яриа хэлэлцүүлэг өрнөсөн байна.

Олон улсын бага хуралд Зөвлөлийн гишүүдийн илтгэл тавьсан салбар хуралдааныг ЭЗХНЗОГ-ын мэргэжилтэн омбудсмен Скотт Адамс хөтлөн чиглүүлж, эвлэрүүлэн зуучлагч Б.Нандинчимэг, Малчдын төлөөлөгчдийн зөвлөх Хариуцлагын зөвлөх олон улсын ТББ-ын зөвлөх хуульч Кейтлин Даниел, ОУСК-ын Байгалийн баялаг ашиглалтын



төслүүдийн дэлхийн портфолио хариуцсан менежер Иан Вехубринк нар хэлэлцэгчээр оролцсон байна. ■



Орон нутгийн харилцааны хэлтэс | 13